



“КАРТЕР” ХХК-Д

ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ
КОМПАНИ

16 дугаар баг, Дархан сум, Дархан-Уул аймаг, 45045
Утас/Факс: (976) 7555-0011
Цахим шуудан: info@dmp.mn
Цахим хуудас: www.dmp.mn

2024.12.06 № 01/2397
танай _____-ны № _____-т

Тодруулга ирүүлэх тухай

“Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХХК-иас Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2024 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зарлаж, 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдөр нээлт хийсэн №ДААТҮТӨХК20240101622 дугаартай “Төмрийн хүдрийн баяжмал тээвэрлэх вагон түрээс” Багц №1 ажил гүйцэтгэгчийг шалгаруулах сонгон шалгаруулалтад танай компани тендер ирүүлсэн байна.

Танай ирүүлсэн тендерийн Маягт №3 Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээллээр ирүүлсэн техникийн тодорхойлолтыг оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тоон гарын үсгээр баталгаажуулсныг тендерийн баримт бичгийн ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзэж байгаа хэдий ч тодруулга авах нь бусад оролцогчийн өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөхгүй тул техникийн тодорхойлолтыг дахин баталгаажуулж ирүүлнэ үү.

Мөн тендерийн ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох гэрээний төлбөрийн үүрэг, нөхцөл, хэмжээ зэрэг нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр татан авсан орлогын дэлгэрэнгүй тайлан дах борлуулалтын орлоготой уялдаж буй эсэхийг тогтоох, мөн техникийн тодорхойлолт дах зорилгоор “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 25 дугаар зүйлд заасныг үндэслэн тодруулах шаардлагатай байна.

Иймд 2024 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн дотор тодруулгын хариу ирүүлнэ үү.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЧАГНААДОРЖ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

4524024300